



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/04

Хараат

Г 2020 оны цэргийн тоо бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, Батлан хамгаалах сайдын 2017 оны А/322 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам”, аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд 2020 оны цэргийн бүртгэл явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: З.Солонго - Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Г.Жаргалмаа – 1 дүгээр багийн Засаг дарга

Гишүүд: Б.Азжаргал - Хэсгийн төлөөлөгч

И.Эрдэнэбат – 2 дугаар багийн Засаг дарга

Г.Дэмбэрэлжав – 3 дугаар багийн Засаг дарга

Д.Мягмардорж – 4 дүгээр багийн Засаг дарга

Д.Бат-Орших – Улсын бүртгэгч

Г.Эрдэнэтуяа- Бичиг хэргийн ажилтан

Г.Энхжаргал- Дотоод ажил, мэдээ хариуцсан ажилтан

2. Цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл алба хаах насны иргэдийн цэргийн бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны 2020 оны 01 дүгээр сарын 27-ны дотор зохион байгуулж явуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (З.Солонго), ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан “Батлан хамгаалах”-ын багц хууль, 2018 онд батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр хаах журам”, 11 дүгээр тогтоолоор батлагдсан

“Цэргийн гэрээт алба хаах журам” зэрэг хууль эрх зүйн баримт бичгийг сурталчлан, тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж тайланг Тамгын газарт ирүүлэхийг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БУДЖАВ